МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС - PMI

2021.IV улирал

2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр

МОНГОЛБАНК

Энэхүү үзүүлэлтийг олон улсад нийтлэг ашиглагддаг аргачлалын дагуу бодлого боловсруулагчид, бизнес эрхлэгчид болон олон нийтийн хэрэгцээнд зориулж улирлын давтамжтай тогтмол гаргаж байна.

1. Худалдан авалтын менежерийн индексийн тухай

Худалдан авалтын менежерийн индекс (PMI) нь бодлого боловсруулагчид, хөрөнгө оруулагчид болон аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудын хувьд эдийн засаг, бизнесийн төлөв байдлыг харах, үйл ажиллагаагаа удирдах, төлөвлөх, урьдчилан таамаглах, шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой үзүүлэлт болдог. PMI нь тооцоход хялбар энгийн аргачлал дээр үндэслэгдэж, албан ёсны статистик тоон мэдээлэл гарахаас өмнө эдийн засаг, бизнесийн төлөв байдлыг тодорхойлохын зэрэгцээ бусад орнуудтай харьцуулалт хийх боломж олгодгоороо давуу талтай. Олон улсын туршлагаас харахад уг индексийг тооцохдоо эдийн засгийн голлох салбаруудын нөлөө бүхий 400 орчим аж ахуйн нэгжүүдийг сонгон түүвэрлэлтэд хамруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, шинэ захиалга, ажил эрхлэлт, бараа материалын нөөц, хүргэлтийн хугацаа болон бусад үзүүлэлтийн талаарх мэдээллийг судалж, эдгээр үзүүлэлт бүрээр индексийн утгыг тооцон, индексийн өөрчлөлтийг харгалзан дүгнэлт өгдөг.

“Худалдан авалтын менежерийн индекс (Purchasing manager index-PMI)” нь эдийн засгийн ерөнхий хандлагыг харуулсан чиглэлийн индекс юм.

Аргачлал: Түүвэр судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдээс үзүүлэлт тус бүрийн хувьд өмнөх улирлаас хэрхэн өөрчлөгдсөн талаар чанарын асуулт асууж, хариултуудыг нэгтгэх замаар тоон буюу индексийн утгад шилжүүлнэ. Индексийг үзүүлэлт тус бүрээр тооцон гаргаж салбаруудын индекс, нийлмэл индекс, нийт эдийн засгийн индексийг тооцоолоход ашиглана.

PMI (тухайн үзүүлэлтийн тархалтын индекс) = (K1 * 1) + (K2 * 0.5) + (K3 * 0)

k1 = *Өссөн гэсэн хариултын хувь*
k2 = *Хэвэндээ гэсэн хариултын хувь*
k3 = Буурсан гэсэн хариултын хувь

Уг индексийн тооцоолсон утгыг ***тархалтын индекс*** гэж нэрлэх бөгөөд PMI=50 бол бизнесийн үйл ажиллагаанд өөрчлөлт ороогүйг, PMI>50 бол бизнесийн үйл ажиллагааны тэлэлтийг, PMI<50 бол агшилтыг тус тус илэрхийлдэг. Энэхүү утга 50-аас холдох тусам тэлэлт эсвэл агшилт ихэснэ. Тодруулбал, PMI-ийн үзүүлэлт өмнөх улирлын үзүүлэлтээс өндөр байвал эдийн засаг илүү хурдтай тэлж (агшиж) байгааг, харин өмнөх улирлаас доогуур байвал илүү багаар тэлж (агшиж) байна гэсэн утгыг илэрхийлнэ.

Энэхүү судалгаанд PMI-ийг эдийн засгийн голлох салбаруудаар тооцохын зэрэгцээ аж ахуйн нэгжийн ажилчдын тоог нь харгалзан жижиг (*49 хүртэл*), дунд (*50-199*), том (*200-с дээш*) гэж ангилан, бүлэг тус бүрээр индексийг тооцож гаргасан. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын орлогын нийт борлуулалтын орлогод эзлэх хувиар нь бүлэг тус бүрийн үзүүлэлтийн тархалтын индексийг жигнэж тухайн үзүүлэлтийн салбар бүр дэх индексийн утгыг тооцлоо. Салбар болон нийт эдийн засгийн PMI-ийг тооцохдоо гол

үзүүлэлтүүдийн нийлмэл[1] индексийг олон улсад нийтлэг ашиглагддаг ач холбогдлын жингээр[2] жигнэн тооцсон болно.

2. ААН-ийн ерөнхий мэдээлэл

Судалгааны түүвэрлэлт хийхдээ Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ)-ны бүртгэл, мэдээллийн баазад тулгуурлан аж үйлдвэр, барилга, дотоод худалдаа (бөөний болон жижиглэн) болон үйлчилгээний салбаруудаас идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй, эх олонлогийг төлөөлөхүйц 500 орчим ААН-үүдийг ***жижиг*** *(49 хүртэл ажилтантай)*, ***дунд*** *(50-199 хүртэл ажилтантай)*, ***том*** *(200-с дээш ажилтантай)* гэж ангилан түүвэрлэлт хийсэн бөгөөд ингэхдээ тухайн ангилалд хамаарах бүх аж ахуйн нэгжүүдээс жилийн борлуулалтын орлогоор тэргүүлэх аж ахуйн нэгжүүдийг түүвэрт сонголоо.

Санал асуулгыг **2021 оны 12 дугаар сарын 06-20**-ны өдрүүдэд **500** аж ахуйн нэгжийн дунд явуулсан бөгөөд ***аж үйлдвэрийн салбарын 123***, ***барилгын салбарын 121***, ***дотоод худалдааны салбарын 121***, ***үйлчилгээний салбарын 135*** аж ахуйн нэгж судалгаанд хамрагдлаа. Ажилчдын тоогоор жижиг ангилалд хамаарах 307 (61%), дунд 115 (23%), том 78 (16%) аж ахуйн нэгжүүд судалгаанд оролцлоо /Хүснэгт 1/.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн тоо, салбар, ажилтны тооны бүлгээр*[3]

Ерөнхий салбар	Салбар	ААН-ийн тоо 2021.III*	Жижиг	Дунд	Том	Нийт	Эзлэх хувь
Аж үйлдвэр (123)	Уул уурхай, олборлолт	1,127	12	5	3	20	4%
	Боловсруулах үйлдвэрлэл	5,946	72	18	5	95	19%
	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	266	3	1	1	5	1%
	Усан хангамж	192	1	1	1	3	1%
Барилга	Барилга	7,455	40	45	36	121	24%
Дотоод худалдаа	Бөөний болон жижиглэн худалдаа	36,805	95	16	10	121	24%
Үйлчилгээ (135)	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	2,093	7	2	1	10	2%
	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажилл	2,292	12	2	1	15	3%
	Мэдээлэл, холбоо	2,237	7	2	1	10	2%
	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	2,304	10	2	1	13	3%
	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1,225	6	1	1	8	2%
	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн ү.а	5,708	14	9	6	29	6%
	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	5,239	5	6	8	19	4%
	Боловсрол	4,628	6	1	1	8	2%
	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	2,767	12	1	1	14	3%
	Урлаг, үзвэр, тоглоом наадам	1,215	1	1	1	3	1%
	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	10,463	4	2		6	1%
Нийт		**91,962**	**307**	**115**	**78**	**500**	**100%**

[1] Салбар бүр дэх гол 5 үзүүлэлтүүдийн индексийг ДНБ-д эзлэх хувиар жигнэн тооцсон үзүүлэлт болно.

[2] Олон улсын туршлагаар PMI-ийг тооцохдоо шинэ захиалга 30%, үйлдвэрлэлийн хэмжээ 25%, ажил эрхлэлт 20%, нийлүүлэлт хугацаа 15%, бараа материалын нөөц 10%-иар жигнэж тооцдог байна. An introduction to the PMI surveys, HIS Markit/.

[3] 2021 оны III улирлын байдлаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн тоо, Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Жилийн борлуулалтын орлогоор ангилан авч үзвэл 50 хүртэл сая төгрөгийн 16 (3%), 50-300 сая төгрөгийн 37 (7%), 300 саяас 1 тэрбум төгрөгийн 54 (11%), 1-2.5 тэрбум төгрөгийн 86 (17%), 2.5-с дээш тэрбум төгрөгийн орлоготой 307 (61%) аж ахуйн нэгж судалгаанд хамрагджээ /Хүснэгт 2/.

Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн тоо, салбар, жилийн борлуулалтын орлогын бүлгээр

Ерөнхий салбар	Салбар	Жижиг	Дунд	Том	Нийт	Эзлэх хувь
Аж үйлдвэр	50 сая₮ хүртэл	3			3	1%
	50-300 сая₮ хүртэл	23			23	5%
	300 сая₮-1 тэрбум₮ хүртэл	20			20	4%
	1-2.5 тэрбум₮ хүртэл	23	3		26	5%
	2.5 тэрбум₮ дээш	19	22	10	51	10%
Барилга	50 сая₮ хүртэл	1			1	0%
	300 сая₮-1 тэрбум₮ хүртэл	2				
	1-2.5 тэрбум₮ хүртэл	1				
	2.5 тэрбум₮ дээш	36	45	36	117	23%
Дотоод худалдаа	50 сая₮ хүртэл	2			2	0%
	50-300 сая₮ хүртэл	6			6	1%
	300 сая₮-1 тэрбум₮ хүртэл	16				
	1-2.5 тэрбум₮ хүртэл	25			25	5%
	2.5 тэрбум₮ дээш	46	16	10	72	14%
Үйлчилгээ	50 сая₮ хүртэл	9	1		10	2%
	50-300 сая₮ хүртэл	7	1		8	2%
	300 сая₮-1 тэрбум₮ хүртэл	10	4	2	16	3%
	1-2.5 тэрбум₮ хүртэл	25	7	2	34	7%
	2.5 тэрбум₮ дээш	33	16	18	67	13%
Нийт	**50 сая₮ хүртэл**	**15**	**1**		16	3%
	50-300 сая₮ хүртэл	**36**	**1**		37	7%
	300 сая₮-1 тэрбум₮ хүртэл	**48**	**4**	**2**	54	11%
	1-2.5 тэрбум₮ хүртэл	**74**	**10**	**2**	86	17%
	2.5 тэрбум₮ дээш	**134**	**99**	**74**	307	61%
Нийт		**307**	**115**	**78**	**500**	**100%**

Тус судалгаанд 2.5 тэрбум төгрөгөөс дээш жилийн борлуулалтын орлоготой, ажиллагсдын тооны бүлгийн хувьд 49 хүртэл ажилтантай буюу жижиг ангилалд хамаарах аж ахуйн нэгжүүд түлхүү оролцлоо.


3. Худалдан авалтын менежерийн индекс (PMI)

Ерөнхий индекс: Монгол Улсын худалдан авалтын менежерийн ерөнхий индекс 2021 оны IV улиралд өмнөх улирлаас 0.9 нэгж хувиар буурч **46.4**%-тай буюу босго утга (50%)-аас бага гарч агших мужид хадгалагдлаа /Дүрслэл 1/. Индексийн утга өмнөх улирлын утгаас буурахад нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа болон шинэ захиалгын индексийн утга буурсан нь голлон нөлөөлөв. Харин ажил эрхлэлт болон үйлдвэрлэлийн индексийн утга өмнөх улирлаас өсч ерөнхий индексийг өсгөх чиглэлд нөлөөлөв.

Шинэ захиалга, үйлдвэрлэл болон ажил эрхлэлтийн индексүүдийн утга босго утгыг даван тэлэлтийн мужид хэвээр хадгалагдсан бол нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа болон түүхий эд материалын нөөцийн индексийн утга босго утгаас бага буюу агших мужид гарлаа /Хүснэгт 3/.

Салбарын ангилал: Эдийн засгийн ерөнхий салбаруудаар авч үзвэл 2021 оны IV улиралд аж үйлдвэрийн салбарын индексийн утга өмнөх улирлын утгаас 2.9 нэгж хувиар буурсан ч **52.1%**-д хүрч босго утгаас өндөр гарлаа. Бусад салбаруудын хувьд дотоод худалдаа 2.3 нэгж хувиар, үйлчилгээ 1.2 нэгж хувиар тус тус өссөн хэдий ч агших мужид хэвээр хадгалагдлаа. Харин барилгын салбарын индекс 5.2 нэгж хувиар буурч **31.4%**-д хүрлээ /Дүрслэл 2/.


Дүрслэл 1. Ерөнхий индекс



Хүснэгт 3. Нийлмэл индекс

Үзүүлэлт	2021.II	2021.III	2021.IV
Шинэ захиалга	38.9↑*[4]	**53.4**↑	**50.8%**↓
Үйлдвэрлэл	40.7↑	**52.6**↑	**53.8%**↑
Ажил эрхлэлт	47.5↑	**52.0**↑	**54.8%**↑
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа **[5]	29.5↓	23.9↓	18.3%↓
Түүхий эд, материалын нөөц	45.0↑	41.2↓	39.8%↓

Дүрслэл 2. Ерөнхий индекс,салбараар



[4] *Өмнөх улирлын индексийн утгатай харьцуулсан өөрчлөлтийг харуулна.
[5] **Урвуу үзүүлэлт бөгөөд 50%-иас дээш гарсан тохиолдолд хугацаа буурч байгааг эсрэг тохиолдолд хугацаа уртсаж байгааг илэрхийлнэ.

Ерөнхий индекс тооцоход хамгийн их хувийн жин /30%/ эзэлдэг шинэ захиалга /эрэлт/-ын индексийн утга аж үйлдвэрийн салбарт босго утгаас давсан, бусад салбарт босго утгаас бага гарсан бөгөөд дотоод худалдааны салбарын индексийн утга өмнөх улирлаас бага зэргийн өсөлттэй гарчээ.

Барилгын салбарын бизнесийн үйл ажиллагаа, дотоод худалдааны салбарын борлуулалтын орлого, үйлчилгээний салбарын бизнесийн идэвхжил зэрэг үзүүлэлтүүдийг үйлдвэрлэл /гарц/ гэсэн индексийн үзүүлэлтэд дүйцүүлдэг бөгөөд тус үзүүлэлтээр дотоод худалдаа болон үйлчилгээний салбарын индексийн утга өмнөх улирлаас өсөлттэй гарсан хэдий ч барилга, үйлчилгээний салбарын индексийн утга агших мужид байна. Харин аж үйлдвэр болон дотоод худалдааны салбарт тэлэх мужид гарчээ.

Ажил эрхлэлтийн индексийн хувьд аж үйлдвэрийн салбарт хэвээр, дотоод худалдаа болон үйлчилгээний салбарт өмнөх улирлын индексийн утгаас өссөн бөгөөд зөвхөн барилгын салбарын индексийн утга агших мужид гарлаа.

Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны бүх салбарын индексийн утга босго утгаас бага гарч буюу хугацаа уртассан үзүүлэлттэй байна. Харин барилгын салбар дахь тус индексийн утга өмнөх улирлын утгаас өсөлттэй гарчээ.

Түүхий эд, материалын нөөцийн үзүүлэлт салбар тус бүрт босго утгаас бага гарч агших мужид байна. Харин дотоод худалдааны салбарын индекс өмнөх улирлаас бага зэргийн өсөлттэй гарлаа /Хүснэгт 4/.


Хүснэгт 4. Нийлмэл индекс, салбараар

Үзүүлэлт	**Аж үйлдвэр**	**Барилга**	**Дотоод худалдаа**	**Үйлчилгээ**
Шинэ захиалга	**62.4%**↓	32.9%↓	46.5%↑	41.3%↓
Үйлдвэрлэл */бизнесийн үйл ажиллагаа, борлуулалт, бизнесийн идэвхжил/*	**61.0%**	33.6%↓	**52.6%**↑	48.5%↑
Ажил эрхлэлт	**58.5%**	35.8%↓	**51.6%**↑	**54.0%**↑
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	14.1%↓	28.7%↑	29.7%↓	18.6%↓
Түүхий эд, материалын нөөц	42.8%↓	16.2%↓	37.9%↑	

Ажиллагсдын тооны ангилал: Аж ахуйн нэгжүүдийг ажилчдын тоогоор жижиг (*50 хүртэл*), дунд (*50-200*), том (*200-с дээш*) гэж ангилан тайлант улирлын худалдан авалтын менежерийн индексийг тооцвол өмнөх улирлын утгаас жижиг ААН-үүд 1.8 нэгж хувиар, дунд ААН-үүд 0.6 нэгж хувиар, том ААН-үүд 0.2 нэгж хувиар тус бүр буурч харгалзан **41.5%**, **39.2%**, **48.9**%-тай гарч, бүх ангиллын хувьд босго утгаас бага буюу агших мужид гарлаа /Дүрслэл 3/.

Нийлмэл индексийг ажиллагсдын тооны бүлгээр задалж харвал жижиг аж ахуйн нэгжүүдийн индексийн үзүүлэлт бүгд босго утгаас бага гарсан бөгөөд ажил эрхлэлтийн үзүүлэлт өмнөх улирлын утгаас өсөлттэй гарчээ. Дунд ангилалд хамаарах аж ахуйн нэгжүүдийн хувьд мөн бүх нийлмэл индексийн утга босго утгаас бага гарсан хэдий ч шинэ захиалга, ажил эрхлэлтийн индексийн утга өмнөх улирлаас сайжирсан харагдаж байна. Том аж ахуйн нэгжүүдийн хувьд шинэ захиалга, үйлдвэрлэл, ажил эрхлэлтийн индекс босго утгаас давсан хэдий ч шинэ захиалга болон нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны индексийн утга өмнөх улирлаас буурсан дүр зурагтай байна /Хүснэгт 5/.

Дүрслэл 3. Ерөнхий индекс, ажиллагсдын тооны бүлгээр



Хүснэгт 5. Нийлмэл индекс, ажиллагсдын тооны бүлгээр

Үзүүлэлт	Жижиг	Дунд	Том
Шинэ захиалга	43.3%↓	41.8%↑	**54.5%**↓
Үйлдвэрлэл	41.5%↓	39.3%	**58.7%**↑
Ажил эрхлэлт	48.1%↑	49.5%↑	**56.8%**↑
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	32.7%↓	28.2%↓	15.3%↓
Түүхий эд, материалын нөөц	36.6%↓	27.3%↓	41.7%

Аж үйлдвэр: Салбарын аж ахуйн нэгжүүдээс 11 төрлийн үзүүлэлтийн өөрчлөлтийн талаар асуусан бөгөөд үзүүлэлт тус бүрийн индексийн утгыг ажилчдын тооны бүлгээр задалсныг Хүснэгт 6-д харууллаа. Жижиг хэмжээтэй аж ахуйн нэгжүүдийн хувьд түүхий эд, материалын үнэ нэмэгдэж, бусад бүх үзүүлэлт буурсан утга үзүүлсэн буюу муудсан тул бүтээгдэхүүний үнээ нэмэгдүүлэх арга хэмжээг авчээ. Харин индексийн утгын хувьд ажил эрхлэлт, нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа өмнөх улирлаас сайжирсан утгыг үзүүлжээ. Дунд аж ахуйн нэгжүүдийн хувьд эрэлт (шинэ захиалга), ажил эрхлэлт өөрчлөгдөөгүй бол түүхий эдийн үнэ болон худалдан авалтын тоо хэмжээ нэмэгдсэнээр бүтээгдэхүүний үнээ нэмэгдүүлсэн байна. Том аж ахуйн нэгжүүдийн хувьд нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа уртасч, бараа материалын нөөц буурсан бол бусад үзүүлэлтийн хувьд босго утгаас өндөр гарсан тул харьцангуй эерэг утгыг үзүүлж байна. Салбарын нийт аж ахуйн нэгжүүдийн түүхий эдийн үнэ болон худалдан авалтын тоо хэмжээ өсч, дуусаагүй үйлдвэрлэл болон бэлэн бүтээгдэхүүний нөөц өссөн үзүүлэлттэй байгаа бол нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа удааширсан хэвээр, түүхий эдийн нөөц буурсан дүр зурагтай байна. Аж ахуйн нэгжүүд салбарын бизнесийн үйл ажиллагааны төлөвийг энэ улиралтай харьцуулахад ирэх улиралд (2022.I) “сайжирна” гэж хүлээж байна.

Хүснэгт 6. Үзүүлэлт тус бүрийн тархалтын индекс, ажиллагсдын тооны бүлгээр

Үзүүлэлт	Жижиг	Дунд	Том	Индекс
Шинэ захиалга	44.9%↓	**50.0%**↑	**65.0%**↓	**62.4%**↓
Үйлдвэрлэл	35.2%↓	40.0%↑	**65.0%**	**61.0%**
Ажил эрхлэлт	48.9%↑	**50.0%**↑	**60.0%**	**58.5%**
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	43.8%↑	32.0%↓	10.0%↓	14.1%↓
Түүхий эд, материалын нөөц	39.8%↓	20.0%↓	45.0%	42.8%↓
Дуусаагүй үйлдвэрлэл	46.0%↓	48.0%↓	**55.0%**↑	**53.8%**↑
Бэлэн бүтээгдэхүүн	43.2%↓	48.0%↓	**60.0%**↑	**57.9%**↑
Бүтээгдэхүүний үнэ	**73.3%**↑	**64.0%**↓	**80.0%**	**78.4%**
Худалдан авалтын тоо хэмжээ	46.0%↓	**56.0%**↑	**65.0%**↑	**63.0%**↑
Түүхий эд, материалын үнэ	**85.2%**	**84.0%**↓	**100.0%**↑	**97.8%**↑
Бизнесийн үйл ажиллагааны төлөв***[6]	46.0%↓	**60.0%**	**85.0%**↑	**80.3%**↑

Барилга: Салбарын аж ахуйн нэгжүүдээс дараах 15 төрлийн үзүүлэлтийн талаар асууж тус бүрийн индексийн утгыг тооцлоо. Улирлын шинж чанартай холбоотойгоор барилгын салбарын шинэ захиалга буурч /*индексийн утга босго утга (50%)-аас бага*/ түүнтэй уялдан үйлдвэрлэл, ажиллах хүчний тоо, худалдан авалтын тоо хэмжээ зэрэг үзүүлэлтүүд босго утгаас бага буюу өмнөх улирлаас буурсан үзүүлэлттэй гарлаа. Гэсэн хэдий ч нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацааны индексийн утга өмнөх улирлын утгаас бага зэрэг сайжирсан, түүхий эд, материалын үнэ өссөн үзүүлэлттэй байна. Тус салбарын аж ахуйн нэгжүүдийн хувьд ирэх улирлын бизнесийн үйл ажиллагааг “муудна” гэж салбарын дийлэнх аж ахуйн нэгжүүд харж байна

Хүснэгт 7. Үзүүлэлт тус бүрийн тархалтын индекс, ажиллагсдын тооны бүлгээр

Үзүүлэлт	Жижиг	Дунд	Том	Индекс
Шинэ захиалга	35.0%↓	22.2%↓	38.9%↓	32.9%↓
Үйлдвэрлэл	36.3%↓	25.6%↓	37.5%↓	33.6%↓
Ажил эрхлэлт	41.3%↓	37.8%↓	31.9%↓	35.8%↓
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	28.8%↑	34.4%↑	25.0%↑	28.7%↑
Түүхий эд, материалын нөөц	25.0%↓	11.1%↓	15.3%↓	16.2%↓
Худалдан авалтын тоо хэмжээ	31.3%↓	17.8%↓	22.2%↓	22.9%↓
Түүхий эд, материалын үнэ	**87.5%**↓	**91.1%**↓	**81.9%**↓	**86.0%**↓
Орон сууцны зах зээлийн идэвхжил	48.6%↓	37.2%↓	37.1%↓	39.7%↓
Борлуулалтын үйл ажиллагаа	40.0%↓	26.7%↓	36.1%↓	34.1%↓
Барилга, угсралтын үйл ажиллагаа	36.3%↓	21.1%↓	34.7%↓	30.9%↓
Туслан гүйцэтгэгч ашиглалт	37.5%↓	25.6%↓	33.3%↓	31.9%↓
Туслан гүйцэтгэгчдийн нөөц	35.0%↑	47.8%↑	44.4%↑	43.3%↑
Туслан гүйцэтгэгчдийн чанар	43.8%↓	41.1%↓	41.7%↓	42.0%↓
Туслан гүйцэтгэгчдийн төлбөрийн хэмжээ	**60.0%**↓	**50.0%**↓	48.6%↓	**51.6%**↓
Бизнесийн үйл ажиллагааны төлөв***	45.0%↑	41.1%↑	**50.0%**↑	46.2%↑

Дотоод худалдаа: Бөөний болон жижиглэн худалдаа эрхлэгчдээс дараах 8 төрлийн үзүүлэлтийн талаар тодруулсан бөгөөд борлуулалтын орлого, ажил эрхлэлт, түүхий эд, материалын үнэ, худалдан авсан барааны хэмжээ зэрэг үзүүлэлт босго утгаас их буюу сайжирсан төлөвтэй байна. Харин шинэ захиалга,

[6] ***Ирэх улирлын буюу 2022 оны I улирлын бизнесийн үйл ажиллагааны талаарх хүлээлт

бараа материалын нөөц буурсан, нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа уртассан үзүүлэлттэй байна. Дунд аж ахуйн нэгжүүдийн бараа материалын нөөц нэмэгдсэн байгаа бол бусад аж ахуйн нэгжүүдэд буурсан үзүүлэлттэй гарчээ. Жижиг хэмжээтэй аж ахуйн нэгжүүдээс бусдад ажил эрхлэлт үйлдвэрлэл, шинэ захиалгын үзүүлэлт харьцангуй сайжирсан дүр зурагтай байна. Энэ улирлын буюу 2021 оны IV улирлын хүлээгдэж буй борлуулалтын талаар асуухад дийлэнх нь “төлөвлөлтөөс доогуур байна” гэсэн хариултыг өгч индексийн утга босго утгаас бага гарсан хэдий ч өмнөх улирлын индексийн утгаас 10.6 нэгж хувийн өсөлттэй гарлаа.

Хүснэгт 8. Үзүүлэлт тус бүрийн тархалтын индекс, ажиллагсдын тооны бүлгээр

Үзүүлэлт	Жижиг	Дунд	Том	Индекс
Шинэ захиалга	34.2%↓	**50.0%**↑	**60.0%**↑	46.5%↑
Борлуулалтын орлого	42.1%↓	**53.1%**↓	**65.0%**↑	**52.6%**↑
Ажил эрхлэлт	47.4%	**56.3%**	**55.0%**↑	**51.6%**↑
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	32.6%	18.8%↑	30.0%↓	29.7%↓
Түүхий эд, материалын нөөц	28.9%↓	**62.5%**↑	40.0%↑	37.9%↑
Худалдан авсан барааны дундаж үнэ	**82.1%**↑	**96.9%**↑	**85.0%**↑	**85.3%**↑
Худалдан авсан барааны хэмжээ	**58.9%**↓	**68.8%**↓	**70.0%**↑	**64.6%**↓
Хүлээгдэж буй борлуулалт	24.2%↑	31.3%↑	45.0%↑	33.3%↑

Үйлчилгээ: Үйлчилгээний салбарын аж ахуйн нэгжүүдээс 8 төрлийн үзүүлэлтийн талаар асууж индексийн утгыг тооцоход бизнесийн идэвхжил суларсан, шинэ захиалга өмнөх улирлаас буурч нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа уртассан зэрэг үзүүлэлттэй байгаа бол ажил эрхлэлт, дуусаагүй ажил үйлчилгээ, түүхий эдийн үнэ болон үйлчилгээний үнэ нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Том ангиллаас бусад аж ахуйн нэгжүүдийн хувьд бизнесийн идэвхжил муу, ажил эрхлэлт буурсан байна. Харин нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа салбарын бүх аж ахуйн нэгжүүдэд уртассан үзүүлэлттэй гарч хамгийн муу утгыг үзүүллээ. Салбарын хэмжээнд ирэх улирлын бизнесийн үйл ажиллагааны төлөвийг энэ улирлаас “сайжирна” гэж төсөөлж байна. Энэ нь өмнөх улирлын индексийн утгаас өссөн үзүүлэлт болж байна.

Хүснэгт 9. Үзүүлэлт тус бүрийн тархалтын индекс, ажиллагсдын тооны бүлгээр

Үзүүлэлт	Жижиг	Дунд	Том	Индекс
Шинэ захиалга	45.2%	32.8%	43.2%↓	41.3%↓
Бизнесийн идэвхжил	48.8%↑	36.2%↓	**52.3%**↑	48.5%↑
Ажил эрхлэлт	48.2%↑	48.3%↑	**56.8%**↑	**54.0%**↑
Нийлүүлэгчдийн хүргэлтийн хугацаа	20.8%↓	25.9%↓	15.9%↓	18.6%↓
Түүхий эд, материалын үнэ	**92.9%**↑	**93.1%**↑	**86.4%**↓	**88.6%**
Үйлчилгээний үнэ	**57.7%**↑	**55.2%**↑	**59.1%**	**58.1%**↑
Дуусаагүй ажил үйлчилгээ	**61.9%**↑	**58.6%**↑	**56.8%**	**57.8%**
Бизнесийн үйл ажиллагааны төлөв**	**52.4%**↑	**50.0%**↑	**54.5%**↓	**53.3%**↑